



МОНГОЛ УЛС  
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2013 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 2/304

Даланзадгад

Дэд зөвлөл байгуулах тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Засгийн газрын 2013 оны 222 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах санаачлага хэрэгжүүлэх, ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн дэд зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Р.Сэддорж -Уул уурхай, байгаль орчин, дэд бүтэц хариуцсан Засаг даргын орлогч

Гишүүд:	Г.Цог- Өрнөх	-Татварын газрын дарга
	О.Бадарч	-Байгаль орчны газрын дарга
	Б.Буяннэмэх	-Мэргэжлийн хяналтын газрын дарга
	Ч.Цэвээндорж	-Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
	Ц.Буяндэлгэр	-Онцгой байдлын хэлтсийн далга
	С.Нарантуяа	-Хөдөлмөрийн хэлтсийн дарга
	С.Энэбиш	-Иргэний нийгмийн төлөөлөл
	Д.Баярсайхан	-“МАК” ХХК-ийн Нарийн сухайт уурхайн дарга /зөвшилцлөөр/
	Д.Хатанбаатар	-“Олон овоот гоулд” ХХК-ийн Хүдэр баяжуулах үйлдвэрийн дарга /зөвшилцлөөр/
	З.Сугармаа	-“Энержи ресурс” ХХК-ийн Компанийн нийгмийн хариуцлага, орон нутгийн харилцааны газрын дарга /зөвшилцлөөр/
	С.Эрдэнэбат	-“Оюу толгой” ХХК-ийн Орон нутагтай байгуулах хамтын ажиллагааны гэрээний зохицуулагч /зөвшилцлөөр/

2.

Ц.Бадралтхүү -“Саусгоби сэндс” ХХК-ийн Олон нийттэй харилцах  
ерөнхийлөгчийн төлөөлөгч /зөвшилцлөөр/

Д.Ариунбилэг -“Мөнхноён суварга” ХХК-ийн Орон нутгийн  
хариуцсан хэлтсийн ажилтан /зөвшилцлөөр/

Нарийн бичгийн дарга: Т.Дөлбаяр -Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга

2. Дээрх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг  
Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах санаачлага хэрэгжүүлэх, ажлыг  
зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн дэд зөвлөл  
/Р.Сэддорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.БАДРАА